



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/60

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 4.1.11.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 12/09 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааг иргэдэд ил тод, хүртээмжтэй хүргэх ажлыг төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.
2. Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, гүйцэтгэлийн дагуу батлагдсан зардлаас санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100129

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2020 оны 02
дугаар сарын 10-ны өдрийн 760 дугаар
захирамжийн хавсралт



ТӨВИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
БАЙГУУЛЛАГУУДААР 2020 ОНД ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН
ЗАРДЛЫН ХУВААРЬ

Д/д	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэр	Санхүүжилтийн төсөл-2020 /Мян.төг/
1	МҮОНТ-ийн Орон нутаг дахь сэтгүүлч	6000.0
2	“Соёмбо” телевиз	6000.0
3	“Хас” телевиз	6000.0
4	“Жи Эм” телевиз	6000.0
5	“Ноён-Уул” богино долгионы радио	4000.0
6	“Өвөрхангайн өнгө” сэтгүүл	3000.0
7	“Өвөрхангай” сонин	3000.0
8	“Өвөрхангайн мэдээ” сонин	3000.0
9	“Өвөрхангайн толь” сонин	3000.0
10	Монголын радиогийн сурвалжлагч	2000.0
11	Uvnews.mn сайт	2000.0
12	Uvmedee.mn сайт	1000.0
13	Төвийн хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	12000.0
НИЙТ		57000.0